



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 23 өдөр

Дугаар А/836.

Ховд

Төсөвт зохицуулалт хийх тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 42 дугаар зүйлийн 42.2 дахь заалт, 61 дүгээр зүйлийн 61.1 дэх заалт, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”- ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Боловсрол, Шинжлэх Ухаан, Спортын сайдын 2020 оны 1а/2788 дугаар албан бичиг, төсвийн байгууллагын төсөв захирагч нарын хүсэлтийн дагуу Орон нутгийн төсвийн байгууллагуудын төсөвт зохицуулалт хийх жагсаалт, дүнг 1 дүгээр хавсралтаар, тусгай зориулалтын шилжүүлгийн Боловсролын байгууллагуудын төсөвт зохицуулалт хийх жагсаалт, дүнг 2 дугаар хавсралтаар, Эрүүл мэндийн байгууллагуудын төсөвт зохицуулалт хийх жагсаалт, дүнг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дээрх байгууллагуудын төсөвт зохицуулалт хийж, зарлагын сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулан батлуулж, мөрдөж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал /-д зөвшөөрсүгэй.

3. Дээрх хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулан өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллахыг сумдын Засаг дарга, төсвийн байгууллагын захирагч нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Zax A/836 Ch

02 4234